

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТОВЧ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

(НАВАГЧАМБА ОВОГТОЙ БААСАНЖАВ)

Хуульч мэргэжилтний нэгдсэн, хараат бус, бие даасан, дэвшилтэт бодлого бүхий холбооны төлөө!

Нэгдсэн бодлого бүхий, бүх хуульч мэргэжилтнээс бүрдсэн Монголын Хуульчдын холбоог бэхжүүлэх хүрээнд: Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Монголын Хуульчдын холбоонд олгосон чиг үүргүүд (өмнө нь төрийн гүйцэтгэж байсан) болох Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нэгдсэн стандартыг тогтоож, мөрдүүлэх, хуульчийг сонгон шалгаруулж, хуульчийн эрхийг олгох, хуульчийг давтан сургах, хууль тогтоогч, хэрэгжүүлэгчид бодлогын нөлөөлөл үзүүлэх, хууль зүйн сургуулиуд, хуульч мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрт магадлан итгэмжлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд тус байгууллага нь судалгааны институт байх, хуульч бүр тодорхой нэг хэрэг, бодлогын асуудал зэрэг нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг хийх боломжтой болохыг сурталчилах, асуудлаар ажлыг цаашид улам бэхжүүлэх, өнгөрсөн хугацаанд хийсэн ажлыг дүгнэн, дутагдалтай зүйлийг засаж ажиллана.

Миний өнөөдрийг хүртэл МХХ-нд хийсэн ажлуудад үндэслэн цаашид хийх ажлын талаар хөтөлбөрөө танилцуулая.

1. Монголын Хуульчдын Холбооны хэтийн болон дунд хугацааны бодлого, стратегийн төслийг чадварлаг, дэвшилтэт, туршлагатай хуульчдын оролцоотойгоор боловсруулж, Зөвлөлөөр батлуулах;
2. Төрөөс шилжүүлсэн МХХ-ны хуульчийг үүргийг бэхжүүлэн, хуулийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллах;
3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нэгдсэн стандартыг бэхжүүлж, хуульчид хариуцлага тооцох нэгдсэн бодлого, тогтолцоо бүхий механизмыг хууль эрх зүйн хүрээнд үр дүнтэй ажиллуулах;
4. Олон улс дахь МХХ-ны нэр хүнд, өнөөг хүртэл бий болгосон хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, Ерөнхийлөгч Ж.Хунангийн хамт Азийн хуульчдын холбоонд 2020 оны 8 сард Азийн хуульчдын чуулга уулзалтыг зохион байгуулах хүсэлт гаргаж, улмаар Азийн холбоонд зөвшөөрөгдсөнөөр Lawasia 33 дахь удаагийн чуулга уулзалтыг Улаанбаатар хотод Монгол

Улсын Ерөнхийлөгчийн эвээл дор зохион байгуулах, ингэснээр монголын хуульчдыг азитивийн улмаар олон улсын түвшинд ажиллах боломжийг нээх;

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмгөөлөгчийн эрх хэмжээг нэмэгдүүлэх, ажиллах баталгааг сайжруулах заалт оруулах;
6. Шүүгчийн нийгэм дэх нэр хүндийг өсгөх, хэргийг хянан шийдвэрлэхэд бие даан, хараат бус ажиллах нөхцөл боломжийг бэхжүүлэх, нэмэгдүүлэх;
7. Прокурор-хуульчаас МХХ-ны үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох, хуульчийн хувьд хөгжих, суралцах, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, прокурор хуульчдаас гаргасан санал, судалгаанд үндэслэн тухайлсан хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажиллах;
8. Нийгэмд хуульчийг, хуульчийн мэргэжлийн ажлыг буюу өмгөөлөгч, хуулийн зөвлөх, шүүгч, прокурор, нотариатын ажил үүргийг таниулах, бодитойгоор, эерэгээр сурталчлах, хуульчийн нэр хүндийг өргөхөөр бодитой ажлуудыг хийх;
9. Хуульчийн сонгон шалгаруулалтыг боловсронгуй, шудрага, чанартай зохион байгуулах ажлыг улам боловсронгуй болгох, шалгалтын нэр хүндийг өсгөх;
10. Эмэгтэй хуульчдыг МХХ-ны бүх нэгж, ажил үүрэгт оролцох байдлыг бодлогоор дэмжиж, Холбооны дүрэмд энэ талаарх зохицуулалтыг оруулах, ажил хэрэг болгох;
11. Залуу, ахмад, эмзэг байдал бүхий, хөгжлийн бэрхшээлтэй хуульчид цаашлаад мэргэшил хооронд шилжилт хийж буй хуульчдын хэрэгцээ шаардлагад тохирсон ажил зохиох, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
12. Мэргэжлийн ажил үүрэг хооронд шилжиж буй хуульчдын эрэлт хэрэгцээнд нийцэх хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж ажиллах
13. Хуульчийн давтан сургалтын чиглэлд: Сургалтын олон талт хэлбэрүүдийг цаашид улам хөгжүүлэх, боловсронгуй болгохын зэрэгцээ сургалтын чанарт анхаарах, сургалтыг зохион байгуулахад салбар эрх зүйн хороодыг илүүтэй дэмжиж ажиллах;

14. Салбар эрх зүйн хороодыг улам бэхжүүлж, сургалт, мэргэшин ажиллах, салбарын хууль тогтоомж, хэлэлцүүлэг, хурал зөвлөгөөнийг салбар эрх зүйн хороонд түшиглэн зохион байгуулахад онцгой анхаарах
15. Зөвлөлийн гишүүдийг салбар хороо, холбооны бусад үйл ажиллагаанд манлайлагчийн үүрэгтэйгээр оролцох, Холбооны төлөө санаачлагатай ажиллахад анхаарах,
16. Үндэсний хэмжээнд бусад мэргэжлийн холбоод, нийгмийн түншлэлийн байгууллагуудтай нийгмийн эрх ашгийн төлөөх хамтын ажиллагааг хөгжүүлэх;
17. Монголын Хуульчдын Холбоо нь дэвшилтэт үзэлтэй, хуульчдын шинэ санал, санаачлагыг дэмждэг байгууллага байж, хуульчдаа бүхий л талаар хөгжүүлэхэд анхаарах;
18. Монголын Хуульчдын Холбооны журам, дотоод хэм хэмжээнд мониторинг хийж, хороод хоорондын хамтын ажиллагааг дэмжсэн, уян хатан, хүндрэл чирэгдэлгүй болгох чиглэлд боловсронгуй болгож ажиллах зэрэг болно.